

# Есүс Христээр дамжин ирэх найдвар

Төгс төгөлдөр болохын тулд Есүс Христийн тусламж яагаад надад хэрэгтэй байна вэ?

Далын ахлагч Ж.Дэвн Корниш ийн хуваалцсан.



Манай гишүүд ихэвчлэн “Би хангалттай сайн хүн мөн үү?” эсвэл “Би үнэхээр селестииел хаант улсад орж чадах уу?” гэж асуудаг. Мэдээж, “хангалттай сайн байна” гэж байдаггүй. Бидний хэн ч авралаа “олж авч” эсвэл “хүртэж” хэзээ ч чадахгүй. Гэхдээ миний ойлгож байгаагаар бид Их Эзэний өмнө хүлээн авагдах эсэхэд гайхах нь хэвийн үзэгдэл юм. . . .

Би шууд бөгөөд тодорхой хэлье. “Би хангалттай сайн байна уу?” эсвэл “Би хаант улсад орж чадах уу?” гэдэг асуултуудын хариулт нь “Тийм ээ! Та хангалттай сайн хүн болох болно” мөн “Тийм ээ, та өөрийгөө зөвтгөх юм уу Бурханы эсрэг бослого гаргахгүйгээр үргэлжлүүлэн наманчилбал хаант улсад орох болно” гэсэн хариулт юм. Тэнгэрийн Бурхан бол биднийг тоглоомоос хасахын тулд ямар нэгэн шалтаг хайж буй зүрх сэтгэлгүй шүүгч биш юм. Тэр бол бүх хүүхэд нь гэртээ эргэн ирж, гэр бүлийнхэнтэйгээ Өөртэй нь хамт үүрд амьдраасай хэмээн юу юунаас илүү хүсэж тэмүүлдэг, төгс хайраар дүүрэн бидний Эцэг билээ. Тэрээр үнэхээр биднийг мөхөөхгүй, харин мөнх амьтай болгохын төлөө Төрсөн Ганц Хүүгээ өгсөн! Энэхүү мөнхийн үнэнд итгэж, эндээс итгэл найдвар, тайтгарлыг авна уу. Тэнгэрлэг Эцэг маань биднийг Өөр лүү нь буцаж ирнэ гэж хүлээдэг юм шүү! Энэ бол Түүний ажил бөгөөд алдар суу бөлгөө. (Ж.Дэвн Корниш, “Би хангалттай сайн байна уу? Би хаант улсад орж чадах уу?,” 2016 оны 10-р сарын Ерөнхий чуулган, 19–20)

## Би “Есүсээр дамжин төгс болгогдох”-ын тулд юу хийж чадах вэ?

Залуу эмэгтэйчүүдийн ерөнхий ерөнхийлөгч асан Кэрол Ф.Макконки эгч ийн заасан.



Бидний ариун байх итгэл найдвар Христэд мөн Түүний нигүүлсэл, ач ивээлд төвлөрдөг. Есүс Христэд болон Түүний Цагаатгалд итгэн, бурханлаг бусаас өөрсдөө татгалзаж [Моронай 10:32–33-ыг үзнэ үү], чин сэтгэлээсээ наманчлах үед цэвэр ариун, толбогүй болох боломжтой. Бид нүглээсээ ангижрахын тулд усанд умбуулах баптисм хүртдэг. Биднийг зүрх сэтгэлээ нээж, Ариун Сүнсийг хүлээн авах үед бодгаль маань ариусдаг юм. Долоо хоног бүр бид ариун ёслолоос хүртдэг. Бид Түүний Сүнсийг өөрсөдтэйгөө үргэлж хамт байлгаж болохын тулд зөв шударга байх чин хүсэлтэй байж, наманчлалын сүнсээр өөрсдөдөө Христийн нэрийг авч, Түүнийг дурсан санаж, зарлигуудыг нь дагахад бэлэн хэмээн гэрээ байгуулдаг. Бид Эцэг, Хүү, Ариун Сүнстэй нэг болохыг үргэлжлүүлэн хичээх явцдаа Тэдний бурханлаг зан чанараас хүртэгчид болдог [2 Петр 1:4-ийг үзнэ үү]. (Кэрол Ф.Макконки, “Ариун байдлын гоо үзэсгэлэн,” 2017 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 127–128)

Арван хоёр төлөөлөгчийн чуулгын ахлагч Дэйл Г.Рэнланд ийн заасан.



Бурхан биднийг хэзээ нэгэн цагт ямар хүн байснаас маань илүүтэй, одоо ямар хүн байгаа мөн ямар хүн болж байгааг анхаардаг. Тэр бидний хичээл зүтгэлийг л анхаардаг. (Дэйл Г.Рэнланд, “Хожмын үеийн гэгээнтнүүд шантралгүй хичээсээр байдаг,” 2015 оны 4-р сарын Ерөнхий чуулган, 43)